



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
АРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар A/123

Мандал

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, 41.2.3 дахь заалт, Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 14 дүгээр хуралдааны 05 тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр сумын аюулгүй нөөцөд өвс, тэжээл худалдан авах ажилд 19,575,000 (арван есөн сая таван зуун далан таван мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Малын тоо толгойн албан татварын хөрөнгийн сангийн зардлаас тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Дэлгэрцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилт болон зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (Б.Цэндбаяр)-д даалгасугай.

ДАРГА

Б.БАНТУЛГА

